



СҮХБААТАР АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

АУДИТЫН ЕРӨНХИЙ ДҮГНЭЛТ:

Сонгуулийн зардлын ажил гүйлгээ нягтлан бодох бүртгэлийн дагуу хөтлөгдөөгүй, хөрөнгийн зарцуулалтанд тавих хяналт хангалтгүй хэрэгжүүлсэн байна.

Аудитын нэр:

Монгол Улсын Ерөнхийлөгчийн сонгуулийн улсын төсвөөс санхүүжүүлсэн зардлын гүйцэтгэл



Баруун-Урт сум
2017 он

АГУУЛГА

Аудитын тайланг бэлтгэсэн:

ААГ-ын аудитын хэлтэс

Сүхбаатар аймаг
дахь Төрийн
аудитын газрын
дарга, тэргүүлэх
аудитор
Менежер

М.Нарантуяа
Г.Даваа

Ахлах аудитор: Н.Болдбаатар
Аудитор: А.Мөнхцэцэг
Б.Мөнхбамбар

2017 оны 8 дугаар сарын 1-ний өдөр

Аудитын тайлан, дүгнэлттэй
холбоотой асуудлаар нэмж тодруулах,
асууж лавлах зүйл байвал багийн
утас: 70512123, 70512127

Газрын дарга, тэргүүлэх аудитор
70518396 дугаарын факсаар
харилцана уу

ХАЯГ:

Сүхбаатар аймаг дахь Төрийн
аудитын газар Баруун-Урт сум 7-р баг
төрийн захиргааны байр №226 тоот
өрөө

Аудитын зорилт, хамарсан хүрээ, арга зүй,
шалгуур үзүүлэлт

Товчилсон үгийн тайлбар

Дэд зорилт-1.1 Төсвөөс олгох хөрөнгийг сонгуулийн хороодод холбогдох журмын дагуу хуваарилсан байна.

Дэд зорилт-1.2: Улсын бүртгэлийн хэлтэс хуваарилагдсан төсвөөс 12.5 сая төгрөгийн хөрөнгийг хэмнэлтгүй, үр ашиггүй зарцуулжээ.

Дэдзорилт-2.1: Сонгуулийн зардлын ажил гүйлгээ нягтлан бодох бүртгэлийн дагуу хөтлөгдөөгүй байна.

Дэдзорилт-2.2: Хөрөнгийн зарцуулалтад тавьсан хяналт хангалтгүй хэрэгжүүлсэн байна.

ДҮГНЭЛТ:.....

САНАЛД ӨГСӨН ТАЙЛБАР:.....

Аудитын зорилт, хамарсан хүрээ, арга зүй, шалгуур үзүүлэлт

Аудитыг Улсын Их Хурлын Төсвийн Байнгын хорооны 2017 оны 02 дугаар тогтоолын дагуу Монгол Улсын Ерөнхий аудитораас 2017 онд нийлүүлэх аудитын болон ажил үйлчилгээний төлөвлөгөөний дагуу Төрийн аудитын тухай хуулиар тодорхойлсон бүрэн эрхийг үндэслэн гүйцэтгэв.

Аудитын зорилт

Монгол Улсын Ерөнхийлөгчийн 2017 оны ээлжит сонгууль зохион байгуулахтай холбоотой улсын төсвөөс олгосон хөрөнгийн зарцуулалтыг шалгаж дүгнэлт гарган зөвлөмж боловсруулан холбогдох байгууллага, албан тушаалтанд танилцуулж олон нийтэд мэдээлэхэд аудитын зорилт чиглэгдлээ. Дээрх зорилтыг хангахын тулд дараах чиглэлээр аудит хийсэн. Үүнд:

- Монгол Улсын Ерөнхийлөгчийн 2017 оны сонгуулийн батлагдсан төсвийг сонгуулийн хороодод холбогдох хууль, журмын дагуу төлөвлөж, хуваарилж, зарцуулсан эсэх;
- Сонгууль зохион байгуулах зардалд холбогдох хууль, журамд нийцүүлэн хяналт тавьсан эсэх

Аудитын хамрах хүрээ

Аудитад аймгийн Сонгуулийн Ерөнхий хороо, аймаг, нийслэл, сум, дүүргийн сонгуулийн тойргийн хороод, аймгийн Улсын бүртгэлийн хэлтэс, Цагдаагийн газрын сонгуультай холбогдох санхүүгийн баримт материалыг хамрууллаа.

Үндсэн мэдээлэл

УИХ-аас 2015 оны 12 дугаар сарын 25-ны өдөр шинэчлэн баталсан Сонгуулийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.1, 16.3, 16.6 дахь заалтын дагуу Ерөнхийлөгчийн 2017 оны ээлжит сонгуулийг 6 дугаар сарын 26-ны өдөр явуулахаар товлон зарлажээ.

Сонгуулийн тухай хуулийн 38 дугаар зүйлийн 38.2 дахь заалтаар сонгууль зохион байгуулахтай холбоотой улсын төсвөөс санхүүжүүлэх зардлын төрлийг заасан бөгөөд СЕХ-ийн 2016 оны 4 дүгээр тогтоолоор сонгуулийн хороодод төсөв хуваарилах, зарцуулах, түүнд хяналт тавих тайлан гаргах журмыг баталжээ.

Аймаг, сумын 14 сонгуулийн хороо, 59 хэсгийн хороодод эхний санал хураалт явуулахад 234.5 сая төгрөг, хоёр дахь санал хураалт явуулах зардалд 78.3 сая төгрөг нийт 312.9 сая төгрөгийн санхүүжилт олгосон байна.

Аудитын арга зүй

Аудитыг гүйцэтгэхдээ Төрийн хяналт шалгалтын стандарт, АДБОУС 100, АДБОУС 400, АДБОУС 4100, Нийцлийн аудитын түр журмыг баримтлан шалгагдагч байгууллагаас авсан мэдээлэл, нотлох зүйлсийг нягтлан шалгах, холбогдох албан тушаалтнуудтай ярилцлага хийх, харьцуулах, дүн шинжилгээ хийх, түүвэрлэлт хийх болон аудитын бусад горим, арга зүйг ашиглаж, аудитын дүн, дүгнэлт, зөвлөмж боловсруулав.

Аудитын шалгуур үзүүлэлт

Дараах хууль эрхийн актыг аудитын шалгуур үзүүлэлтийн эх сурвалж болгон ашиглав. Үүнд:

- Төрийн аудитын тухай хууль
- Монгол Улсын 2017 оны төсвийн тухай хууль
- Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль
- Сонгуулийн тухай хууль
- Сонгуулийн төв байгууллагын тухай хууль
- Сонгуулийн автоматжуулсан системийн тухай хууль
- Сонгуулийн Ерөнхий хорооны 2016 оны 04 дүгээр тогтоол
- Дээрх хуулиудтай нийцүүлэн гаргасан тогтоол, журам

ТОВЧИЛСОН ҮГИЙН ТАЙЛБАР

УИХ	Улсын Их Хурал
ЗГ	Засгийн газар
ҮАГ	Үндэсний аудитын газар
ИТХ	Иргэдийн төлөөлөгчдийн хурал
СЕХ	Сонгуулийн ерөнхий хороо
СХХ	Сонгуулийн хэсгийн хороо
АСХ	Аймгийн сонгуулийн хороо
ЦЕГ	Цагдаагийн ерөнхий газар
ЦГ	Цагдаагийн газар
УБХ	Улсын бүртгэлийн хэлтэс
АДБОУС	Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт
НББ	Нягтлан бодох бүртгэл

Дэд зорилт-1 Монгол Улсын Ерөнхийлөгчийн 2017 оны сонгуулийн батлагдсан төсвийг холбогдох хууль, журмын дагуу төлөвлөж, хуваарилж, зарцуулсан эсэх

Аймгийн сонгуулийн хороо холбогдох журмын дагуу сумдад сонгуулийн зардлыг хуваарилсан боловч анхан шатны баримт бүрдлийг бүрэн хангаагүй 4.3 сая төгрөгийн зөрчил илэрлээ.

Дэд зорилт 1.1 Төсвөөс олгох хөрөнгийг сонгуулийн хороодод холбогдох журмын дагуу хуваарилсан байна.

1.1.1 Монгол Улсын Ерөнхийлөгчийн 2017 оны ээлжит сонгуулиар аймгийн сонгуулийн хороо болон сонгууль зохион байгуулахад чиг үүргийн дагуу хамтран оролцдог аймгийн УБХ, ЦГ-т улсын төсвөөс нийт 379.2 сая төгрөг батлагдаж, гүйцэтгэлээр 378.4 сая төгрөгийг зарцуулж, 0.8 сая төгрөг зарцуулагдаагүй үлдсэн байна.

Төсөв захирагч	Батлагдсан төсөв	Олгосон санхүүжилт	Гүйцэтгэл	Зарцуулагдаагүй үлдэгдэл
АСХороо	312.9	312.9	312.1	0.8
УБХэлтэс	57.6	57.6	57.6	0
Цагдаагийн газар	8.7	8.7	8.7	0
Нийт дүн	379.2	379.2	378.4	0.8

/ сая.төг /

1.1.2 Сонгуулийн ерөнхий хорооноос аймаг, сумдын сонгуулийн хороодод 312.9 сая төгрөгийн төсөв хуваарилжээ. Уг төсвийг аймгийн сонгуулийн хороо эдийн засгийн ангилалын дагуу сумдын нутаг дэвсгэрийн хэмжээ, сонгогчийн тоо, санал авах байр тэдгээрт ажиллах гишүүдийн тоо, СЕХ-ны төсөв хуваарилсан тайлбар зэргийг үндэслэн батлагдсан төсвийг хуваарилсан байна. Үүнд:

Хүснэгт №1 /мян.төг/

№	Сонгуулийн хороодын нэрс	Хэсгийн хороод	Сонгогчийн тоо	Хуваарилсан төсөв		
				06.26	07.07	Нийт дүн
1	Аймгийн сонгуулийн хороо			59107.4	58343.0	117450.4
2	Асгат сумын сонгуулийн хороо	3	1203	9450.8	1116.0	10566.8
3	Баяндэлгэр сумын сонгуулийн хороо	6	3163	16954.6	2157.0	19111.6
4	Баруун-Урт сумын сонгуулийн хороо	9	13198	27889.8	2656.0	30545.8
5	Дарьганга сумын сонгуулийн хороо	3	1991	9330.8	896.0	10226.8
6	Мөнххаан сумын сонгуулийн хороо	5	2911	14310.0	1700.0	16010.0
7	Наран сумын сонгуулийн хороо	2	1133	6906.2	659.0	7565.2
8	Онгон сумын сонгуулийн хороо	4	2483	11750.4	1228.0	12978.4
9	Сүхбаатар сумын сонгуулийн хороо	5	2058	14259.6	1790.0	16049.6
10	Түвшинширээ сумын сонгуулийн хороо	4	2077	11985.4	1463.0	13448.4
11	Түмэнцогт сумын сонгуулийн хороо	2	1584	7006.2	659.0	7665.2
12	Уулбаян сумын сонгуулийн хороо	5	1947	14420.0	1810.0	16230.0
13	Халзан сумын сонгуулийн хороо	4	1129	11885.4	1463.0	13348.4
14	Эрдэнэцагаан сумын сонгуулийн хороо	7	4347	19279.2	2394.0	21673.2
	Дүн	59	39224	234535.8	78334.0	312869.8

1.1.3 Цагдаагийн ерөнхий газраас аймгийн цагдаагийн газарт сонгуулийн үйл ажиллагааг зохион байгуулахтай холбогдуулан 8.7 сая төгрөг хуваариласанаас хоолны зардалд 6.8 сая, шуудан холбоонд 0.7 сая, тээвэр шатахуунд 1.2 сая төгрөгийг тус тус зарцуулжээ.

1.1.4 Оюуны өмч, Улсын бүртгэлийн ерөнхий газраас аймгийн Улсын бүртгэлийн хэлтэст сонгуулийн үйл ажиллагааг зохион байгуулахтай холбогдуулан 57.6 сая төгрөг хуваарилагдаж, бүрэн зарцуулжээ. УБХ-т хуваарилагдсан хөрөнгийг зарлагын эдийн засгийн ангиалалаар авч үзвэл:

дд	Үзүүлэлт	Төсөв	Гүйцэтгэл	/ сая.төг / Зөрүү
1	Бичиг хэргийн зардал	13.5	13.5	-
2	Шуудан холбооны зардал	0.8	0.8	-
3	Унааны зардал	2.0	2.0	-
4	Албан томилолтын зардал	7.3	7.3	-
5	Сургалтын зардал	1.4	1.4	-
6	Сонгуулийн автоматжуулсан систем ашиглахтай холбоотой зардал, цалин	26.3	26.3	-
7	Сонгуулийн тоног төхөөрөмж хүлээн авах, хүлээлгэн өгөх зардал	6.3	6.3	-
	Нийт дүн	57.6	57.6	-

Дэд зорилт 1.2 Улсын бүртгэлийн хэлтэс хуваарилагдсан төсвөөс 12.5 сая төгрөгийн хөрөнгийг хэмнэлтгүй, үр ашиггүй зарцуулжээ.

1.2.1 Монгол Улсын Ерөнхийлөгчийн ээлжит сонгуулийг зохион байгуулах нийт зардлын 37.5 хувь буюу 117.5 сая төгрөгийг аймгийн Сонгуулийн Хороо, 62.5 хувь буюу 195.4 сая төгрөгийг сумын Сонгуулийн хороонд зарцуулсан байна. Аймгийн Сонгуулийн хороо улсын төсвөөс сонгуулийн зардалд хуваарилагдаж ирсэн 312.9 сая төгрөгөөс 312.1 сая төгрөгийг зарцуулж 0.8 сая төгрөгийг буцаан төвлөрүүлжээ.

1.2.2 Аймгийн сонгуулийн зардлын гүйцэтгэлийн 56.6 хувь буюу 176.5 сая төгрөгийг ажилтнуудын урамшуулал болон хоолны зардалд, 9.7 хувь буюу 30.4 сая төгрөгийг саналын хуудас, төхөөрөмж хүргэх, буцаан татах зардалд, 13.5 хувь буюу 42.2 сая төгрөгийг хороодын үйл ажиллагаа, санал авах байрыг тохижуулахад, 10.4 хувь буюу 32.3 сая төгрөгийг унаа, томилолтод, 7.3 хувь буюу 22.8 сая төгрөгийг сургалт, сурталчилгааны материал хүргэхэд, 2.5 хувь буюу 7.9 сая төгрөгийг бусад зардалд зарцуулсан байна. Аймгийн сонгуулийн хорооны гүйцэтгэлийг зардлын зүйл ангиар авч үзвэл :

№	Зардлын нэр	Төсөв	Гүйцэтгэл	Үлдэгдэл
1	Сургалтын зардал	13.20	13.20	0.0
2	Тогтоол, протокол, бусад маягт хэвлүүлэх зардал	0.25	0.25	0.00
3	Бичиг хэргийн зардал	15.30	15.30	0.0
4	Шуудан холбооны зардал	14.90	14.90	0.0
5	Унааны зардал	28.40	28.40	0.0
6	Сурталчилгааны зардал	8.00	8.00	0.0

7	Сурталчилгааны материал хүргэх зардал	1.60	1.60	0.0
8	Санал авах байр бэлтгэх	11.80	11.80	0.0
9	Саналын хуудас хүргэх	7.40	7.40	0.0
10	Санал тоолох төхөөрөмж хүргэх, буцаан татах зардал	16.10	16.10	0.0
11	Мэдээ дамжуулах зардал	6.90	6.86	0.04
12	Томилолтын зардал/ Сонгуулийн үр дүн/	3.90	3.90	0.0
13	Эрчим хүчний эх үүсгэвэр бэлтгэх зардал	4.96	4.93	0.03
14	Болзошгүй зардал	3.00	3.00	0.0
15	Сонгуулийн байгууллагын ажилтны урамшуулал, хоолны зардал	147.50	147.30	0.2
16	МТБ-ийн гишүүн, даамлын урамшуулал, хоолны зардал	29.70	29.20	0.5
НИЙТ ДҮН		312.91	312.14	0.77

1.2.3 Сонгуулийн зардлыг санхүүгийн баримт, нягтлан бодох бүртгэлийн ажил гүйлгээтэй тулган баталгаажуулахад анхан шатны баримтын бүрдэл бүрэн хангаагүй 4.3 сая төгрөгийн зөрчил илэрлээ. Үүнд:

- Онгон сумын сонгуулийн хороо эрчим хүчний эх үүсвэрт зарцуулсан 0.2 сая төгрөг, Сүхбаатар сумын сонгуулийн хороо санал авах байр бэлтгэх тохижуулах, бичиг хэрэг, шуудан холбооны зардалд нийт 1.8 сая төгрөг, Аймгийн сонгуулийн хороо унааны зардал болон томилолтын зардлын 2.3 сая төгрөгийн ажил гүйлгээнд анхан шатны баримтын бүрдэл дутуу гүйлгээ хийгджээ.

1.2.4 Улсын бүртгэлийн хэлтэст хуваарилагдсан төсвөөс хүчин төгөлдөр бус анхан шатны баримт бүрдүүлэн зарцуулалт гаргасан, төсвийг хэмнэлтгүй зарцуулсан, норм нормативаас илүү бодож олгосон томилолт, урамшууллын зардал болох нийт 12.5 сая төгрөгийн зөрчил дутагдал илэрлээ. Үүнд:

- ▶ Бичиг хэргийн зардлаас 6.1 сая төгрөгийн материал норм нормативаас хэтрүүлэн бодож бэлтгэн нийлүүлэгч байгууллага руу шилжүүлсэн, материалыг бэлтгээгүй байж бэлтгэсэн мэтээр зарцуулалтыг гаргаж хөрөнгийн дутагдал бий болгосон.
- ▶ Сонгуулийн үйл ажиллагаатай холбогдуулан зарим сургалт хийгдээгүй байхад хүчин төгөлдөр бус анхан шатны баримт бүрдүүлэн томилолтын зардлаас 2.6 сая төгрөгийн хөрөнгө зарцуулсан. Мөн томилолтын зардлаас 1.0 сая төгрөгийг илүү бодож олгосон зөрчил дутагдал илэрлээ.
- ▶ Улсын бүртгэлийн хэлтэс нь сонгуулийн үйл ажиллагаатай холбогдолгүй өөрийн урсгал үйл ажиллагааны зардалд хамааралтай шуудан холбооны зардал 0.7 сая төгрөгийг сонгуулийн зардлаас төлсөн.
- ▶ Сонгуулийн бичиг баримт болон тоног төхөөрөмж хүлээн авах, хүлээлгэн өгөх зардлаас баримтаар нотлогдохгүй, бодит бус зарцуулалт гарган 2.1 сая төгрөгийг тээвэр шатахуунд зарцуулсан зөрчил дутагдал илэрлээ. Дээрх зөрчил дутагдлын 11.8 сая төгрөгт төлбөрийн акт тогтоов.

Сонгуулийн зардлын ажил гүйлгээ нягтлан бодох бүртгэлийн дагуу хөтлөгдөөгүй, хөрөнгийн зарцуулалтанд тавих хяналт хангалтгүй хэрэгжсэн байна.

Дэд зорилт 2.1 Сонгуулийн зардлын ажил гүйлгээ нягтлан бодох бүртгэлийн дагуу хөтлөгдөөгүй байна.

2.1.1 Аймаг, сумын сонгуулийн хорооны нягтлан бодогч нар СЕХ-ны 2016 оны 04 тогтоолоор баталсан “Сонгуулийн хороодод төсөв хуваарилах, зарцуулах, түүнд хяналт тавих, тайлан гаргах тухай журам”-ын 2, 3 дугаар хавсралтад заасны дагуу сонгуулийн зардлын нэгдсэн тайланг гаргасан байна. Харин сонгуулийн зардлын орлого, зарлагын гүйлгээг Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль болон СЕХ-ны 2017 оны 04 сарын 26-ны өдрийн 113 дугаар албан тоотын 1 хавсралтад заасны дагуу НББ хөтлөгдөөгүй байна. Энэ нь НББ-ийн тухай хууль болон СЕХ-ны тогтоолыг зөрчжээ.

Дэд зорилт 2.2 Хөрөнгийн зарцуулалтад тавьсан хяналт хангалтгүй хэрэгжсэн байна.

2.2.1 Аймгийн Сонгуулийн хорооны дарга, болон гишүүд СЕХ-ны 2016 оны 04 тогтоолоор баталсан “Сонгуулийн хороодод төсөв хуваарилах, зарцуулах, түүнд хяналт тавих, тайлан гаргах тухай журам”-ын 3.4¹-т заасны дагуу нэгдсэн удирдамжаар 2 удаа 13 суманд ажиллажээ.

2.2.2 Аймаг, сумдын сонгуулийн хороод анхан шатны баримтын бүрдэл дутуу зарлага гаргасан, ажил гүйлгээг нягтлан бодох бүртгэлийн дагуу хөтлөөгүй зэрэг зөрчил дутагдал илэрсэн. Аймаг, сумдын сонгуулийн хороодоос төсвийн зарцуулалтад хяналт тавьсан тэмдэглэл хөтлөгдөөгүй, хяналт хэрэгжээгүйгээс дээрх зөрчил дутагдал гарсан байна. Энэ нь Сонгуулийн ерөнхий хорооны 2016 оны 04 дүгээр тогтоолоор баталсан “Сонгуулийн хорооны төсөв хуваарилах, зарцуулах, түүнд хяналт тавих, тайлан гаргах тухай журам”-ын 3 дугаар зүйлийн 4¹-т заасан заалтыг зөрчсөн байна..

¹ ...аймаг нийслэлийн сонгуулийн хороо нь сум дүүргийн сонгуулийн хорооны, төв комисс нь салбар комиссын сонгуулийн зардлын зарцуулалтад тус тус хяналт тавина.

Холбогдох байгууллагаас ирсэн санал:



**СҮХБААТАР АЙМГИЙН
СОНГУУЛИЙН ХОРОО**

№ 07.31

№ 43

танай _____ -ны № _____ -т

**СҮХБААТАР АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАРТ**

Монгол Улсын Ерөнхийлөгчийн сонгууль зохион байгуулахтай холбогдон гарсан хөрөнгийн зарцуулалтанд хийсэн аудитын тайлантай танилцлаа.

Аймгийн сонгуулийн хороо батлагдсан төсвөө сонгуулийн хуулийг иргэдэд сурталчилан таниулах, хуулийн хэрэгжилтийг хангах, иргэдэд мэдээллийг хүргэх, иргэдийг сонгуульдаа идэвхитэй оролцуулах талаар яриа ухуулга хийх, хяналт тавих зэрэг үндсэн үйл ажиллагаандаа хууль, журмын дагуу зарцуулсан болно.

Цаашдын үйл ажиллагаандаа алдаа дутагдал гаргахгүй байх тал дээр шат шатандаа онцгой анхаарч хяналтыг сайн хэрэгжүүлж танай байгууллагаас ирүүлсэн зөвлөмжийг мөрдөн хамтарч ажиллах болно.



ДАРГА

Ж.ТҮВШИНЖАРГАЛ

ДУГНЭЛТ

- Сонгуулийн Ерөнхий Хорооноос баталсан төсвийг холбогдох журмын дагуу аймаг, сумдын сонгуулийн хороодод хуваарилсан боловч анхан шатны баримтын бүрдэл дутуу зарлага гаргасан, ажил гүйлгээг нягтлан бодох бүртгэлийн дагуу хөтлөөгүй, хөрөнгийн зарцуулалтанд тавих хяналтыг хангалтгүй хэрэгжүүлсэн байна.
- Аймгийн улсын бүртгэлийн хэлтэст хуваарилагдсан төсвийн хөрөнгөнөөс 12.5 сая төгрөгийг хөрөнгийг үр ашиггүй үрэлгэн зарцуулжээ.

ЗӨВЛӨМЖ

Аймгийн сонгуулийн хороонд:

1. Дараа дараагийн сонгуулийн үйл ажиллагааг зохион байгуулахтай холбогдуулан сонгуулийн зардлын ажил гүйлгээг нягтлан бодох бүртгэлийн дагуу хөтөлж байх
2. Сонгуулийн төсвийн зарцуулалтад тавих шат шатны хяналтыг чанаржуулж, хэрэгжүүлсэн талаарх тэмдэглэлийг хөтөлж, тайлагнаж байх
3. Анхан шатны баримтын бүрдэл дутуу байхад ажил гүйлгээ хийдэг явдлыг таслан зогсоож, баримтыг үнэн зөв, иж бүрдлийн дагуу хөтөлж, хэвших

Улсын бүртгэлийн хэлтэст:

1. Төсвийг үндэслэлтэй төлөвлөж, батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулж байх.

ТАЙЛАН БИЧСЭН:

АХЛАХ АУДИТОР *[Signature]* Н.БОЛДБААТАР
АУДИТОР *[Signature]* А.МӨНХЦЭЦЭГ
[Signature] Б.МӨНХБАМБАР

ХЯНАЖ БАТАЛГААЖУУЛСАН:

ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР,
ДАРГА *[Signature]* М.НАРАНТУЯА
АУДИТЫН МЕНЕЖЕР *[Signature]* Г.ДАВАА



СҮХБААТАР АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗРЫН ДАРГА,
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОРЫН ТУШААЛ

2017 оны 08 сарын 02 өдөр

Дугаар А/08

Баруун-Урт

Нийцлийн аудитын тайланг
баталгаажуулах тухай

Монгол Улсын Ерөнхий Аудиторын 2014 оны 03-р сарын 27-ны өдрийн 121 тоот тушаалаар батлагдсан "Нийслэлийн болон аймгийн аудитын газрын дарга, тэргүүлэх аудиторт зөвшөөрөх бүрэн эрх"-ийн 5, 11, "Нийцлийн аудитын түр журам"-ын 9 дүгээр зүйлийн 9.2 дахь заалтуудыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

Нэг. "Монгол Улсын Ерөнхийлөгчийн сонгуулийн улсын төсвөөс санхүүжүүлэх зардлын гүйцэтгэл"-д хийсэн нийцлийн аудитын тайланг баталгаажуулсугай.

Хоёр. Тус аудитаар тогтоосон акт, хариуцлага тооцуулах албан шаардлагыг хавсралтаар баталгаажуулсугай.

Гурав. Аудитын тайланд тусгасан зөвлөмжийг хэрэгжүүлж ажиллахыг Сүхбаатар аймгийн сонгуулийн хорооны дарга /Ж.Түвшинжаргал/, Улсын бүртгэл бүртгэлийн хэлтсийн дарга /Ц.Энх-Амгалан/ нарт даалгасугай.

ДАРГА,
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР *Шарантуяа* М.НАРАНТУЯА



D:/Bichig hereg/2017/tushaal

Сүхбаатар аймаг дахь Төрийн аудитын газрын
дарга, тэргүүлэх аудиторын 2017 оны 02 сарын
02-ны өдрийн 4/03 тоот тушаалын хавсралт

“Монгол Улсын Ерөнхийлөгчийн сонгуулийн улсын төсвөөс санхүүжүүлэх
зардлын гүйцэтгэл”-д хийсэн нийцлийн аудит

Дугаар	Акт, албан шаардлагын төрөл, код		Алдаа, зөрчлийн товч утга	Акт, албан шаардлагын товч утга	Мөнгөн дүн /сая төгрөг/
1/49	Акт	УАГ-НАГ/2017/04-НА	Улсын бүртгэлийн хэлтэст хуваарилагдсан төсвөөс томилолтын зардлыг илүү бодож олгосон.	Томилолтын зардлыг илүү бодож олгосон 1007120 /нэг сая долоон мянга нэг зуун хорин/ төгрөгийг нягтлан бодогч С.Доржпагмаар төлүүлэх.	1.0
2/50	Акт	УАГ-НАГ/2017/04-НА	Улсын бүртгэлийн хэлтэс нь сонгуулийн үйл ажиллагаатай холбогдуулан зарим сургалт хийгдээгүй байхад томилолтын зардлаас хөрөнгө зарцуулсан, бичиг хэргийн зардлыг норм нормативаас хэтрүүлэн бодож бэлтгэн нийлүүлэгч байгууллага руу шилжүүлсэн, бодит бус зарцуулалт гарган, баримтаар нотлогдохгүй шатахуун зарцуулсан зэрэг төсвийг үр ашиггүй, зориулалт бус зарцуулсан	Тус зөрчлийн нийт 10829425 /арван сая найман зуун хорин есөн мянга дөрвөн зуун хорин таван/ төгрөгийг Улсын бүртгэлийн хэлтсийн дарга Ц.Энх-амгалан болон холбогдох албан тушаалтнуудаар төлүүлэх.	10.8
1/66	Албан шаардлага	УАГ-НАГ/2017/04-НА	Төсвийг үр ашиггүй, зориулалт бус зарцуулан Төсвийн тухай хуулийг зөрчиж, албан үүргээ хангалтгүй хэрэгжүүлсэн.	Төсвийн тухай хуулийг мөрдөөгүй, албан үүргээ хангалтгүй гүйцэтгэсэн Сүхбаатар аймгийн Улсын бүртгэлийн хэлтсийн нягтлан бодогч /С.Доржпагма/-д холбогдох хууль тогтоомжид заасны дагуу сахилгын шийтгэл ногдуулах	-
2/67	Албан шаардлага	УАГ-НАГ/2017/04-НА	Төсвийг үр ашиггүй, зориулалт бус зарцуулан Төсвийн тухай хуулийг зөрчиж, албан үүргээ хангалтгүй хэрэгжүүлсэн.	Төсвийн тухай хуулийг мөрдөөгүй, албан үүргээ хангалтгүй гүйцэтгэсэн Сүхбаатар аймгийн Улсын бүртгэлийн хэлтсийн дарга /Ц.Энх-Амгалан/-д холбогдох хууль тогтоомжид заасны дагуу сахилгын шийтгэл ногдуулах	-